


БАТЛАВ:

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД



Л.ХАЛТАР

БАТЛАВ:

МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ



Д.НАРАНПҮРЭВ

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ ХООРОНД АВТОТЭЭВРИЙН САЛБАРТ
ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ САНАМЖ БИЧИГ**

2020 оны 11 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 02/17

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын автотээврийн салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, зорчигч ба ачаа тээвэр, тээвэр-логистикийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах нэгдсэн тогтолцоог бий болгох, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн автотээврийн үйлчилгээг хөнгөвчлөх, үндэсний тээвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, олон улсын тээвэрт өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид “Яам” гэх/, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь дор дурдсан чиглэлээр хамтран ажиллахаар харилцан ойлголцож, энэхүү санамж бичгийг байгуулав.

Хоёр. Хамтын ажиллагааны чиглэл

Монгол Улсын Их хурлаас 2009 онд 64 дүгээр тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор доор дурьдсан ажлыг хамтарч хийж хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1. Монголын тээвэрчид олон улсын тээвэрлэлт саадгүй гүйцэтгэхэд шаардлагатай гэрээ, хэлэлцээр, конвенцид нэгдэн орох, байгуулахад уг гэрээ, хэлэлцээрийн орчуулгын зардлыг Холбооноос хариуцах, шаардлагатай тооцоо судалгаа хийх;

2.2. Системтэй, харилцан уялдаа бүхий сургалтын тогтолцоог нэвтрүүлж, сургалтыг чанаржуулах, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, хяналтын нэгдсэн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлсэн цахим систем, салбарын хүний нөөцийн талаар мэдээллийн нэгдсэн сантай болох зорилгоор “Автотээврийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах нэгдсэн тогтолцоо” төслийг Холбооны санхүүжилтээр 2020 онд Талууд хамтран хэрэгжүүлж, 2021 оноос эхлэн автотээврийн салбарт нэвтрүүлэх;

2.3. Эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, найдвартай ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах, ачаа тээврийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ачаа илгээгч, тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, агуулахын үйлчилгээ эрхлэгчдийг нэгдсэн мэдээллээр

хангах “Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн систем”-ийг 2021 оноос эхлэн автотээврийн салбарт нэвтрүүлэх;

2.4. Холбооноос “аюултай ачаа”, “жолоочийн ажил амралтын дэглэм”, “ачааг аюулгүй ачих, бэхлэх, тээвэрлэх” сургалтыг зохион байгуулах, сургалтын асуудал хариуцсан бусад төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах, холбогдох шийдвэр гаргуулах;

2.5. Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг хамтран судлах, хуулийн хүрээнд холбогдох шийдвэр гаргах.

Гурав. Бусад зүйл

3.1. Талууд хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллана.

3.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутамд хэлэлцэж дүгнэнэ.

3.3. Талууд энэхүү “Санамж бичиг”-т дурьдсан “Автотээврийн салбарын хүний нөөцийг чадавхижуулах нэгдсэн тогтолцоо” ба “Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн систем”-ийг хамтран гүйцэтгэх талаар гэрээ байгуулж ажиллана.

3.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү “Санамж бичиг”-т нэмэлт өөрчлөлт оруулж болно.

3.5. Санамж бичгийг хоёр хувь үйлдсэн бөгөөд бичвэрүүд нэгэн адил хүчинтэй байна.

Дөрөв. Хугацаа

4.1. Энэхүү “Санамж бичиг” нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд 2025 оны 11 дугаар сарын 19-ны өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.2. Санамж бичгийг цуцлах талаар талууд албан ёсоор санал гаргаагүй тохиолдолд санамж бичиг нь анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА



Ё.ЖАРГАЛСАЙХАН

1118268563 5919487 СБТ9513

МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.НЯМДАВАА